

МОНГОЛ ХЭЛНИЙ “ХООРОНД” ГЭХ ҮГИЙН УТГА, ХЭРЭГЛЭЭ

Ч.Бямбаханд

Товч хураангуй: Монгол хэлний “qoyurundu” гэх орон цагийн нэрийн утга, хэрэглээг ойролцоо утгатай *dumda*, *jayür-a*, *jabsar* зэрэг үгсийн ялгаанаас тодруулж болно. Ийм учраас энэ судалгаанд “qoyurundu” гэх үгийн шууд бус утгатай хэлц хэллэгээр илрэх хэлбэрийг голлох бус, харин шууд утгаараа хэл зүйн тогтолцоонд хэрхэн илэрч болохыг жишээгээр тодруулан гаргахыг зорьсон болно. Үүний тулд “qoyurundu” гэх үгийн хэл зүйн шинжийг тайлбарлаж, улмаар орон цагийн утга хэрхэн илэрч буйг жишээгээр тодруулах нь чухал билээ. Учир нь ойролцоо утгатай эдгээр үгсийг оновчгүй хэрэглэхэд найруулгын алдаа үүсдэг тул нарийвчлан шинжлэх нь найруулгын өнгө аясыг зохистой болгоод зогсохгүй монгол хэл шинжлэл, заах арга, практик хэл зүйн ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: орны нэр, цагийн нэр, орон цагийн нэрийн утга, хэрэглээ

Хэл нь өөр хоорондоо хэв шинжээрээ ялгардаг бөгөөд бүтээврийн хэв шинж нь тухайн хэлний бүтээврийг залгах аргаас хамааран задлаг (аналитик) ба нийлэг (синтетик) гэж хуваагддаг. Задлаг хэл нь үндсэн нэр үгийг хэвээр үлдээх туслах үг эсвэл үгийн дараалалд тулгуурладаг бол нийлэг хэл нь нэр үгийг салангид хэсгүүдтэй хослуулах эсвэл дүрмийн ойлголтуудыг үндсэн нэр үгтэй нэгтгэдэг. Залгамал хэлний (агглютинатив) бүлэгт багтах монгол хэл нь синтетик хэлнээс урвуу хамааралтай тул “qoyurundu” нь үг, өгүүлбэрт хэрхэн тохиолдож буйг жишээгээр гаргаж, орон цагийн утгыг задлан шинжилж нэгтгэн дүгнэх аргаар тэдгээрийн үүрэг-утга зүйн ялгааг тодруулан гаргаж болно. *qoyurundu*, *dumda*, *jayür-a*, *jabsar* зэрэг ойролцоо утгат үгс нь юмс үзэгдлийн утгын холбоог үүсгэх үндэс болж өгөхийн зэрэгцээ орон цагийн ба орон цагийн бус ойлголтуудыг тодруулахад чухал үүрэгтэй бөгөөд утгын хувьд ялгаа нь төдий л нарийн анзаарагдахгүй боловч хэлний хэрэглээнд тодорхой болдог.

Монгол хэлнээ а) газар, орон, дэвх, ловх, уул, шил, хайрхан, дов, манх, даваа, нуруу, хяр, шанаа, хөтөл, уулын хавирга, уулын хөл, уулын хормой, өвөр, булан, хад, сэрвэн, суваг, агуй, орд, уурхай, цооног, нүх, далай, арал, хойг, тэнгис, нуур, цөөрөм, мөрөн, гол, горхи, байц, бэлчир, жалга, ганга, тохой, гуу, булаг, цээл, худаг, эх, хүрхрээ, харз, хөвөө, ташуу, далан, хашлага, бууц, үхэг, эрэг, гарам б) тэртээ, чанад, энэтээ, цөл, дээд, дээр, дээш, орой, доорд, доор, доогуур, дорогш, доош, зүүн, дорно, баруун, өрнө, өмнө, хойд, умар, дунд, хооронд, зүг, зовхис, этгээд, чиг, төв, хөндлөн, хажуу, дагуу, сэжүүр, солгой, буруу, ич, урагш, хойно, хойш, цаад, цаана, энэтээ, наана (Монгол утгын зүйл хуваасан толь бичиг, 1956) зэрэг үгийг орны утга бүхий хэсэгт багтаадаг. Утгын талаас орон цагийн хэсэгт багцлагдах дээрх үгс нь хэл зүйн хувьд ялгаатай зүйл нэлээдгүй байна. Үүнийг монгол хэл шинжээчдийн бүтээлээс тодруулан үзье.

Монгол хэл шинжлэлд үгсийг аймаглахдаа *qoyurundu*, *dumda*, *jayür-a*, *jabsar* зэрэг үгийг дайвар үг, дагавар үг, орон цагийн харьцааны нэр, орон цагийн нэр хэмээн нэрийдэх зөрөөтэй үзэл хандлага байсаар иржээ. Үүнийг бүлэглэж үзвэл,

Б.Х.Тодаева дайвар үгийг бүтээвэр зүйн шинжээр нь 1. үүсмэл бус 2. үүсмэл гэж хоёр хуваагаад үүсмэл бус үгэнд *нааш, арай, орой, үргэлж, хааяа, эрт, бүрэн, бут, цөм, одоо* зэрэг үгс нь үл хувилах идэвхгүй язгуураас үүсэхийн зэрэгцээ орчин цагийн монгол хэлэнд дагаврын өмнө тохиолдоно. Харин үүсмэл нь нэр үг, тэмдэг нэр, төлөөний үг, үйл үг болон бусад үгсийн аймгаас дагаврын аргаар үүсдэг гээд утгаар нь а) орон заах (дотор, дор, дээр, ойр, цааш, өмнө, гадаа, хойно, *хооронд, дунд*, нааш, энд, тэнд, холоор) б) цаг заах (одоо, орой, үдэш, эрт, урьд, хойш, дараа, үргэлж, даруй, хааяа) в) үйл байдал заах (улам, бут, цөм, сэм, хага, яаруу, гэнэт, хэтэрхий, нэвт, халт, мулт, тус тус, ахин дахин, суга, бүрэн, сайн, цэвэр) г) хэмжээ зэрэг заах (маш, огт, нэн, тун, бага, бас, цөөн, арай, олон) (1951) зэрэг үгсийг хамруулсан бол язгуурын буюу эртний дайвар үгэнд хага, бут, эмт, тас, бяц, няц, яз, шаз, өм, цөм, халт, мөлт; үүсмэл дайвар үгэнд өнөд, үлэмжид, хүндэт, насад, үргэлжид, нэр үгийн айгаас дайвар үгийн айд шилжиж буй үгсэд “доор, дотор, гадна, өмнө, хойно, *хооронд, дунд*, эрт, орой, урьд, одоо, үргэлж, даруй” (Лувсандэндэв, 1956) гэх мэт. П.Бямбасан дайвар үгийн айг 1) язгуур дагавар гэж салгахад төвөгтэй болсон боловч олонх нь үүсмэл, нэр үгийн хувиллаар заримдаг хувирдаг, орон цагийн тодорхой утга бүхий, өгүүлбэрт биеэ даасан гишүүн болдог. Голдуу үйл үг, хааяа нэрийн зүйлд холбогдох “энд тэнд, наана цаана, дээр доор, дотор гадна, одоо дэргэд, байнга, *хооронд*” гэх мэт үгс (үүсмэл буюу дутмаг, заримдаг дайвар үг) 2) үүсмэл бус язгуурын, үндсэн хэлбэрээрээ үг зүйн олон хувиллаар үл хувирах боловч бүгдээрээ үйл үг бүтээх үндэс болдог, үгийн сангийн бодит утга нь бүдэг, олонх эрдэмтэд өгүүлбэрт биеэ дааж, байц гишүүн болдог гэж үзэж, ямагт үйл үгтэй холбогдон өмнө нь орж, туслах үүрэг гүйцэтгэдэг “хага, бут, нэвт, бяц, мулт, цөм, гялс гялс, сэр сэр” гэх мэт үгс байна. 3) нэн, тун, маш, час, тас, пад, арай, пиг, цал, цэлдэн гэх мэт тэмдэг нэр, тэмдэг нэрээс үүссэн үйл үгийн өмнө хэрэглэгддэг бас нэг хэсэг үг байна (1968) гэх мэтээр дайвар үгэнд багтаажээ.

Харин халх монгол хэлний дагавар үгэнд “дээр, дор, дотор, өмнө, *хооронд, дунд*, хүртэл” орон заасан, “хойш, өмнө, хүртэл, дотор, турш, урьд” цаг заасан, “мэт” харьцуулсан, “төлөө, тул” зорилго заасан утгатай үгийг хамруулжээ (Тодаева, 1951). Мөн өгүүлбэр дэх харьцаагаар нь дагавар үгийг 1) дагавар үг-нэр үг: адли, багта, багаар, бэе, газгаа, нюрган, сасуу, тала, хүүл 2) дагавар үг-дайвар үг: дээрэ, дээрэхээ, дээгүүр, доро 3) үйлшсэн дагавар үг: оротор, оруулжа, хүрэтэр, туласа 4) тусгай дагавар үг: гадна, дээр, дээрээ, дээрэхээ, дээгүүр, дэргэдэ, доро, дороо, доогуур, *дунда, дундаа, дундаһаа, дундуур, зуураа*, мэтэ, өөдэ, орондо, саана, сааша, саагуур, соо, сооһоо, соогоо, соогуур, тэндэ, тула, түлөө, туршада, тушаа, тухай, тухайтай, тээшэ, тээшээ, тээгүүр, урда, урид, урдаһаа, урдуур, уруу, хойно, хойноһоо, хойшо, *хоорондо*, хамта, шахуу, шэнээн, шэнги, янзтай (Санжеев, 1962) хэмээн үзсэн бол Ц.Жанчивдорж “дээр, дор, *дотор*, өмнө, *хооронд, дунд*, хүртэл, хойш, уруу” зэрэг үг нь орон заасан, “хойш, өмнө, урьд, хүртэл, дотор, турш” гэсэн үг нь цаг хугацааг, “хамт, цуг” хамыг, “шиг, мэт” харьцуулсан, “төлөө, тул, тулд шалтгааныг, учир, учраас, дээрээс, тул” нь зорилгыг тус тус зааж бусад үгтэй ямар ч дагаваргүй холбогдоно (1970) гэжээ. Буриад хэлний задлаг бүтцийг туслах буюу дагавар үгээр нь нэр (адли, багта, багаар, бэе, газгаа, нюрган, салуу, тал, хүүл) ба жинхэнэ дагавар үг (собственно послелог)-ээр илэрдэг (Алексеев, 1962) гээд жинхэнэ дагавар үгнээ “гадна, дээрэ, дээрэхээ, дээгүүр, дэргэдэ, доро, дороо, дороһоо, доогуур, *дунда, дундаа, дундаһаа, дундуур, зуура*, өөдэ, саана, сааша, саагуур, соо, сооһоо, соогоо, соогуур, тэндэ, туршада, тушаа, тээшэ, тээһээ, тээгүүр, урда, урид, урдаһаа, урдуур, хойноһоо, хойшо, *хоорондо*” гэх мэт орон цагийн нэрийг оруулж, задлаг бүтэц үүсгэнэ гэжээ. Жич, “орондо, тул, төлөө, тухай, уруу, хамт, шахуу, шэнээн, шэнги, янзатай” гэх мэт дагавар үгс гэгчийг багтаасан байна. Д.А.Алексеев энэхүү задлаг бүтцээ утгаар нь орон ба цаг, адилтгасан ба хамтатгасан, шалтгаан ба зорилго, тоо ба хэмжээ, зэрэгцсэн ба орлосон утга илтгэнэ гэж үзсэн байна. Ш.Барайшир дагавар үгийг утгаар нь дээрх байдлаар орон ба цаг, зорилго ба шалтгаан, адилтгах ба хүч нэмэх, тоо ба

хэмжээ заах утгатай (Барайшир) гэж үзсэн байна. Харин Б.Х.Тодаева “дайн-ы өмнө, жил-ийн турш, бороо-н-оос өмнө, сар болсон-ы дараа” гэхчлэн орон цагийн нэр нь өмнөх жинхэнэ нэр болон цагт нэрийг харьяалах, гарахын тийн ялгалаар захирч буйг ерөнхийд нь гаргасан бол (1951) Ц.Ж.Цыдыпов орны нэр нь туслах үүргээр орж, задлаг бүтэц үүсгэхдээ “юмын дээр/доор, юмсын дотор ба гадна, юм руу зүглэх ба чиглэх (тушаа), хажуу ба тойрон” гэсэн орны утгыг илтгэдэг бол зэрэгцэх цагийн утга (дороо, зуура) илтгэнэ (1972) гээд “шалтгаан, хир хэмжээ, адилтгал, орлол боломж” зэрэг утга илтгэдэг тухай өгүүлсэн байна.

Мөн Ш.Лувсанвандан нэр үгийг а) гүйцэд ялгаллагдах үг (нэр үг, тэмдэг үг, төлөөний үг, тооны үг) б) хагас ялгаллагдах үгст одоо, үүрд, хожим, хаана, энд, тэнд, дээр, доор, гадна, дотор, ойр, хол, дунд, өмнө, хойно, ер, гэнэт, маргааш, цааш, дээгүүр, хойш, дундуур, хааш, эрт, орой, *хооронд*, магад, хамт, тухай, лав, өнөө, цаад, наад (1939) гэх мэт үгийг хамруулсан бол П.Бямбасан “ерөөс, ердөө, үнэхээр, сайн, муу, лав, магад, хурдан” зэрэг үгийг дайвар үгэнд тооцолгүйгээр “энд, тэнд, наана, цаана, дээр доор, дотно гадна, одоо, дэргэд, байнга, *хооронд*” нь үүсмэл нэр үгийн хувиллаар заримдаг хувилдаг бол “хага, бут, нэвт, бяц, мулт, цөм, гялс гялс, сэр сэр” нь үүсмэл бус “нэн, тун, маш, час, тас, тэс, пад, арай, пиг, цал” нь тэмдэг нэрээс үүссэн үйл үгийн өмнө хэрэглэгдэх үгс хэмээн 3 бүлэгт хуваажээ (1968). Ш.Лувсанвандан эдгээр үгсийг орон цагийн харьцааны нэр хэмээн үзсэн бол (Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц, Монгол хэлний үг нөхцөл хоёр нь), хэлний үгсийг зөв ангилсны нэг шалгуур нь нэг үг нэг л үгийн аймагт хамаарагдах явдал юм. Харин өгүүлбэрт ямар нэг гишүүний үүргийг голлон гүйцэтгэх боловч бусад аль ч гишүүний үүрэг гүйцэтгэж болдог гээд *qoyurundu*, *dumda* нь орших орон заах нэрс, хоорондуур гэвэл тодорхойгүй зүгт хөдлөх орон заана (Өнөрбаян, 2004) гэсэн бол М.Базаррагчаа орон цагийн нэрийн хувиргалын талаас дэлгэрэнгүй тайлбарлаж (2005) орон цагийн нэрд багтаан үзжээ.

Үүнээс үзвэл, *dumda*, *qoyurundu*, *jayür-a* гэх орон цагийн нэр нь нэрлэхийн тийн ялгалаар хувилахгүй бөгөөд өгүүлбэрт орон цагийн байц гишүүний үүргээр тохиолдоно. Гэвч заримдаа өгүүлбэрт тодотгол гишүүний байранд мөн зэрэгцээ хэлц хэллэгт шилжсэн утгаар ч тохиолддог. Аливаа хэлэнд ойролцоо утгатай үг байна гэдэг бол юм үзэгдлийг улам нарийн дүрслэх боломж олгож байгаа хэрэг (Сүхбаатар, 2012). *qoyurundu* ~ *dumda*, *jayür-a*, *jabsar* гэх үгс нь ойролцоо утгатай тул “*qoyurundu*” гэх орон цагийн нэрийн үүрэг-утга зүйн ялгааг хэрэглээний онцлогоос нь тусгайлан авч үзэж болно.

Монгол хэлний *dumda*, *qoyurundu*, *jayür-a*, *jabsar* гэх үгийн утга, давтамж, хэрэглээг 2011 онд Лайпцигийн их сургуулиас гаргасан монгол хэлний корпусаас *dumda*, *qoyurundu*, *jayür-a*, *jabsar* гэх үгсийг харьцуулж үзэхэд дараах онцлог ажиглагдаж байна. Нийт өгөгдлийн 377,892 өгүүлбэрт *dumda* нь 3028 удаа давтамжтай тохиолдож, 201-д эрэмбэлэгдэн 5 дугаар түвшинд хамаарна. Харин *qoyurundu* нь 1261 удаа давтамжтай, 537-д эрэмбэлэгдэн, 7 дугаар түвшинд, *jayür-a* нь 363 удаа давтамжтай 1965 дугаарт эрэмбэлэгдэн, 8 дугаар түвшинд байгаа бол *jabsar* нь 79 удаа давтамжтай, 7651-д эрэмбэлэгдэн, 1 дүгээр түвшинд байна (corpora.uni-leipzig.de) Давтамжийг хувиар нь авч үзвэл, *dumda* 64%, *qoyurundu* 27%, *jayür-a* 1%-д нь тохиолдож байгаа бөгөөд орон цагийн утгат жинхэнэ нэр болох *jabsar* нь 8% байгаа нь нэг талаас монгол хэл заах арга, практик хэл зүй, нөгөө талаас орон цагийн нэрийн утгын ялгаа найруулгын өнгө аяс, ойролцоо ба ялгаатай талыг авч үзэхэд чухал ач холбогдолтой юм. Ш.Лувсанвандан монгол хэлний орон цаг, зүг чиг заасан бүлэг үгсийг дутмаг нэрээр авч үзээд орон зүг чиг (дээр, доор, хойно, урд, энд, тэнд, гадна, дотно, цаана, наана, *завсар*, *хооронд*, *дунд*, өмнө, зүүн, баруун), цаг хугацаа (эрт, орой, одоо, маргааш, өнө, үүрд, хожим, үргэлж, гэнэт), заасан үгсийн хоорондын харилцааг заах үгс (тухай, тул, төлөө, учир хамт) (Лувсанвандан, 1951) хэмээн “*jabsar*” гэх үгийг орон цагийн нэр хэмээн ялгажээ. Харин монгол хэлний “*dumda*, *qoyurundu*, *jayür-a*” гэх орон цагийн нэр нь “*jabsar*” гэх орон цагийн утгат жинхэнэ нэрээс ялгарах ялгаа нь найруулгын жишээнээс тодорч буй нь сонирхолтой юм.

И.Я.Шмидт үйлийн болсон орны утгыг тодруулахад “... *ᠵᠠᠵᠢᠷ-а, qoᠵur, dumda...*” зэрэг үгийг дайвар үгэнд оруулаад (1931) “*ᠵabsar*” гэх үгийг оруулаагүй бөгөөд “*ᠵᠠᠵᠢᠷ-а*” гэх үгийг тус бүтээлийн 97-р талд дагавар үгэнд багтаан үзжээ. Харин Г.Рамстедт *qoᠵurundu* гэх үгийг *ᠬᠣᠷ* (дунд), *ᠬᠣᠷ dund*᠎ᠠ (дунд), *ᠬᠣᠷᠨ* (дунд), *ᠬᠣᠷᠨᠳᠠᠵᠢᠷ* (хоорондуур), *ᠬᠣᠷ zᠢᠷ* (замын дунд) гэж тэмдэглэжээ. (Ramstedt G.J., 1935, p. 192b) Монгол хэлэнд *qoᠵurundu, dumda, ᠵᠠᠵᠢᠷ-а, ᠵabsar, qoᠵur-na -du* (N_{dat-loc.}), *qoᠵurundu-ᠵᠢᠷ* (N_{instr.}) *qoᠵurundu-aᠴᠠ* (N_{abla.}) зэрэг үгсийн ялгаа нь найруулгын зүйн талаас зарим үед солин найруулах боломжтой байдаг. Эдгээр үгс нь заримдаа орон зааж, заримдаа цаг зааж, ард нь салган онцлох сул баймжит бүтээвэр “л”, зэрэгцүүлэн онцлох сул баймжит бүтээвэр “ч” ордог байна. Тухайлбал,

$$qoᠵurundu \begin{bmatrix} l & qoᠵurundu l \\ \check{i} & qoᠵurundu \check{i} \end{bmatrix}$$

Жишээ нь: Энэ хооронд ч дээ мөдгүй байх (цаг), Энэ хооронд ч дээ амжихгүй байх (цаг), Энэ хооронд л боломжтой (цаг), Энэ хооронд ч хурдан даа (цаг) гэхэд цагийн утгаас гадна өгүүлэгчийн баймж илэрдэг. Мөн ерөнхийлөн хамаатуулах нөхцөлөөр хэлбэржсэн “хооронд+оо” гэх үгийг авч үзье. Тухайлбал,

- хоорондоо+V;

а. 1) төстэй, нийцтэй, зохицолтой зүйлс:

- хоорондоо+V (-х); хоорондоо эвлэрэх (хүлээн зөвшөөрөх), хоорондоо тохирох~хоорондоо зохицох (нийцтэй), хоорондоо уусах (нэгдэх, нийлэх), хоорондоо нэвчих (өөр хоорондоо холилдон жигд тархах), хоорондоо эвлэх (хүмүүс үгээ ойлголцож, эвсэх), хоорондоо итгэх, хоорондоо найдах
- хоорондоо+V (-х) + N; хоорондоо эвлэрэх үг (хүмүүс бие биеэ ойлголцох үг), хоорондоо тохирох орд (нийцтэй), хоорондоо зохицох хүнс (шингүүртэй)
- хоорондоо+N; - хоорондоо ивээл (зурхайн ухааны 12 жил хэмээх ойлголттой холбоотой);

а. 2) төсгүй, нийцгүй, зохицолгүй зүйлс:

- хоорондоо+V (-х); хоорондоо марга-лд-х (хүмүүс өөр хоорондоо маргах, санал зөрөх, ойлголцохгүй), хоорондоо авалцаагүй (учир зүйн уялдаа холбоогүй), хоорондоо авалцаагүй (хоорондоо зохицоогүй), хоорондоо зохицохгүй хүнс (шингүүргүй)
- хоорондоо+N; хоорондоо харш (зурхайн ухааны 12 жил хэмээх ойлголттой холбоотой), -хоорондоо зайтай (даа) (орон: хоёр юм хоорондоо алс хол); хоорондоо зайгүй а.завсаргүй б) шилж. салж хагацашгүй гэх мэт. Мөн “хоорондоо ч зайгүй найзууд даа; хоорондоо замтай, хоорондоо жимтэй; хоорондоо зай барих (холдож хөндийрөх)” гэх мэтээр ярианы хэлэнд ашигладаг байна.
- хоорондоо+Nadj.; - хоорондоо сайн (1. эвтэй найртай 2. сэтгэлтэй); хоорондоо л болж байвал боллоо доо; - хоорондоо ч өөр дөө; “найз нөхдийн хооронд ч нарийн сайн тооцоо хэрэгтэй” гэхийг “найз нөхдийн дунд ч” гэж найруулж болно. Хоорондын зай, хоорондын асуудал, хоорондын хямрал (эрх ашгийн зөрчил) *qoᠵurundu+ᠵᠢᠷ l; qoᠵurundu-ᠵᠢᠷ ᠴi; qoᠵurundu, dumda, ᠵᠠᠵᠢᠷ-а, ᠵabsar+ni; dumda, qoᠵurundu, ᠵabsar, ᠵᠠᠵᠢᠷ-а+ki ni; qoᠵurundu-ᠵᠢᠷ ki* гэхэд хамаатуулах утга бүхий “-ki” нь өгүүлбэрт орон цагийн нэрийг хамжсан тодотгол гишүүн болгож хувиргадаг.

Монгол хэлний өгүүлбэр дэх үгс нь үндсээр холбогдвол хамжих, нөхцөлөөр холбогдвол найрах арга гэж үздэг. Тэмдгийн ба тооны нэр нь нэр, үйл үгнээ, авиа ба дүрс дуурайх үг нь зөвхөн үйл үгнээ тодотгох утгатай тэг үндсээр хамждаг. Жинхэнэ нэр нь үйл үгнээ харьяалахын бус тийн ялгалаар, жинхэнэ нэртэй харьяалах, жишихийн тийн ялгалаар найрч холбогддог бол орон цагийн нэр нь харьяалахын тийн ялгалаар нэр үгтэй, гарахын тийн ялгалаар хааяа өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар үйл үгэнд найран захирагдана. Жишээлбэл, *dumda*, *qoyurundu*, *jaγūr-a*, *jabsar* гэх үгс нь голын дунд, замын дунд, замын дундуур, сарын дунд, сарын дундуур, сэтгэлийн дотор гэх мэтээр ялгасан тохиолдолд ил хэлбэрээр илэрнэ. Мөн малчдын хооронд, уяачдын хооронд, намуудын хооронд; - бидний хооронд, эдний хооронд, тэдний хооронд, та нарын хооронд, энэний хооронд, тэрний хооронд; - улс орнуудын хооронд, Монгол, Оросын хооронд; Монгол, Францын хооронд; Өндөрхаан Улаанбаатарын хооронд, хоёр орны хооронд, хоёр улсын хооронд, банкны хооронд, дансны хооронд, байгууллагын хооронд, орнуудын хооронд, замын хооронд, талын хооронд, иргэдийн хооронд, холбооны хооронд, багийн хооронд, компанийн хооронд, хүмүүсийн хооронд, төгрөгийн хооронд, насны хооронд, сарын хооронд, парламентын бүлгүүд хооронд; - хадны завсар, авдрын завсар, шүүгээний завсар, өрхний завсар, хумсны завсар, цонхны завсар; хичээлийн завсар, чулууны завсар; - хормын зуур гэх мэт.

Мөн *dumda*, *qoyurundu*, *jaγūr-a*, *jabsar* гэх орон цагийн нэр нь харьяалахын тийн ялгалаар хэлбэржиж нэр үгтэй холбогдож найран захирагдахын зэрэгцээ өгүүлбэрт харьяаны тодотголлын үүргээр орно. Жишээлбэл, дундын баримтлал, дундын эзэмшил, сум дундын эмнэлэг, үд дундын цаг, шөнө дундын үе, дундын хувилбар, хоорондын гэрээ, хоорондын хэлэлцээр, хоорондын харилцаа, хоорондын түншлэл, хот хоорондын зорчигч, хоорондын асуудал, хоорондын явдал, завсрын бодол, завсрын үе, завсрын өнгө, завсрын дамжлага, зам зуурын найз, хэсэг зуурын үзэгдэл, ойр зуурын үг, түр зуурын юм гэх мэт.

Монгол хэлний “*dumda*, *qoyurundu*, *jaγūr-a*, *jabsar*” гэх үгс нь ихэвчлэн гарахын тийн ялгалаар хэлбэржиж заримдаа өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржвэл үйл үгэнд найран захирагдана. Жишээлбэл; хооронд+V; “хооронд зохио-н, хооронд амьдар-ч, хооронд байгуул-сан, хооронд тогт-оо-сон, хооронд бол-ж, хооронд үүс-ээд, хооронд үүс-сэн, хооронд хий-сэн, хооронд бол-лоо, хооронд бол-но, хооронд ажил-ла-на, хооронд бол-х, хооронд ажил-ла-х, хооронд үргэлж-лэ-х, хооронд хэлбэ-лэ-ж” гэх мэтээр ихэвчлэн “үүсгэх, бий болгох, бүтээх” гэсэн утгатай үйл үгийн язгуурт захирагдаж өгүүлбэрт цагийн байц гишүүний үүргээр тохиолдоно. Мөн “хооронд-уур, дунд-уур, зуур-аар, завсар-аар, “хоромхон зуурт хавчуулагдсан, хурдан зуурт нэгдэж, түргэн зуурт батлах, түргэн зуурт дээшлүүлэх, завсарт хавчуулагдах, завсарт орж”, “дундуур явах, хоорондуур гүйх, завсраар цухуйх” гэх мэтээр өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэрждэг бол харьяалах, гарахын тийн ялгал шиг гүйцэд хэлбэрждэггүй, зөвхөн тухайн хугацаанд багтах хэмжээ заасан үйл явдлыг илтгэдэг байна.

Монгол хэлний *qoyurundu* гэх орон цагийн нэрийн утгыг өгүүлбэрийн жишээгээр орон ба цаг заасан утгыг тайлбарлан үзье.

• *qoyurundu*:

1) орон зайн утга

а. 1) хоёр юмын хоорондын орон зай

- хоёр юмын хооронд
- *хоёр цонхны хооронд* номын шүүгээ байрлуулжээ.
- *цонх, тавцан хоёрын хооронд* зай гарах ёсгүй... (www.setguul.barilga.mn)
- *хоёр цэгийн хоорондох* зайг хэрхэн олох вэ?
- *хоёр нүдний хоорондох зай* гэх мэт.

- хоёр газар, улс орны хооронд
- Арван гурван наснаас тавин зургаан насыг хүртэл *Шарын гол ба Улаанбаатар хоёрын хооронд* Дагвын өвсийг зөөж, Балдангийн түлээг тээсээр, өдий хүрсэн тул, зам дахь уул, давааг ч андахгүй, энхэл донхлыг ч эндэхгүй, нүхнээс гарч хошхирах тарвагыг ч бараг таних бөгөөд нисэн өнгөрч одох шувууг ч төлөв мэднэ (Д.Н. “Соёлыг гайхав”).
- Даруй өглөө харьсан боловч, үдэш санагдан эгэж ирсээр, нэгэнт хэд хэдэн сар болж, *Баруун дамнуурчны ба Гандангийн дэнж хоёрын хооронд* нэг нарийхан шинэ зам нээгдэв. (Д.Н. “Ламбугайн нулимс”) - *Дарьганга, Наран хоёрын дунд* байдаг том элс бий. (www.dailynews.mn) гэхэд хооронд, дунд гэх ойролцоо үгс нь хоёр юмын завсарт, хооронд, дунд гэсэн орны зайн утга илтгэнэ.
- *Монгол, Японы хооронд* дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн арга хэмжээ албан ёсоор эхэллээ (www.ikon.mn); -Энэ асуудлыг хэлэлцэх үеэр *улс орнуудын хооронд* ямар нэгэн зөрчил гарна гэж би бодохгүй байна (www.dailynews.mn).
- хоёр хүний хооронд
- бид хоёрын хооронд болсон
- *Эцэг эхийн хоорондын харилцаа* хүүхдийн хөгжил, зан харилцаанд чухал үүрэгтэй. (mn.bm) - Хүүхдээ хооллох үед *ээж хүүхэд хоёрын хооронд* эерэг харилцаа үүсдэг. (www.unicef.org/mongolia/mn/first-foods-for-baby)
- a. 2) хоёроос дээш тус тусдаа юмсын хооронд
- Тэр хийдийн хажууд үүдэн дээр нь шүхэр, туг ба хийморь зэргийг хийсгэсэн *хэдэн гэрийн хооронд* эр эм, лам хар хэдэн зуун хүн ийш тийш бужигналдах ба энд тэнд хэсэг хэсгээр бүлэглэнэ (Д.Н. “Үзэгдээгүй юм”).
- ... Энэ бол *тархины янз бүрийн хэсгүүдийг хооронд нь* холбох янз бүрийн... (mn.wikipedia.org)
- ... төгрөгийн ханш гадаад валютын эсрэг ихэвчлэн сулрах хандлага, ...хязгаарлалт тавиагүй буюу *эдгээр хувьсагчдын хооронд* багасгасан... (www.mongolbank.mn).
- Энэ нутгийн гадарга нь Орхон Туулын савын 1500-2000 метр өндөртэй бэсрэг, нам уулс, цав толгод, *тэдгээрийн хооронд* орших талархаг гадарга бүхий тогтоцтой (www.wikipedia.org).
- ... *зогсоолуудын хооронд* 3,6 км зайтай бол нэг зогсоолоос гараад нөгөө зогсоолд хүрээд ... 20 кг масстай нэгэн төрлийн саваа хоёр үзүүрээрээ тулгуурыг дарна (itembank.eec.mn).
- a. 3) өөр хоорондоо, өөр зуураа, тодорхойгүй орон
- Хоол цайны цагт орж, идэж уугаад бусад цагт *хоорондоо* дэмий гүйлдэн явна (Д.Н.) гэх мэт.
- Бүх хүмүүсийн хооронд дэмий үг дайх хэрэггүй; - Энэ нутгийн гадарга нь Орхон Туулын савын 1500-2000 метр өндөртэй бэсрэг, нам уулс, цав толгод, *тэдгээрийн хооронд* орших талархаг гадарга бүхий тогтоцтой. (www.wikipedia)
- 2) цаг хугацааны утга
- хоёр цаг, үйл явдлын хооронд
- хоёр цаг, хугацааны хооронд (эрин зуун, жаран, жил, улирал, он, сар, долоон гариг, өдөр, цаг, минут, секунд, нас гэх мэт)
- Цаг уурын дулаарлаас үүдэн мөнх цэвдэг элэгдэн Хархираа, Түргэн, Мөнххайрхан, Цамбагарав, Сайр уулсын мөсөн бүрхүүлийн талбай *1992 оноос 2002 оны хооронд* 30 орчим хувиар багассан байна (www.dailynews.mn); Хүн амын тооллого ирэх *арван*

- нэгдүгээр сарын 11-17-ны хооронд болох гэж байна (www.dailynews.mn). - Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор энэ сарын 8-15-ны хооронд ойн үндэсний чуулган хуралдана (www.mne.mn) гэхэд он, сар, өдөр буюу хоёр цагийн хоорондох хугацааг тодорхой зааж буйг *dumda*, *ᠵᠠᠶᠢᠷ-а*, *ᠵᠠᠪᠰᠠᠷ* гэх үгээр солин найруулах боломжгүй ч “цагийн+хооронд, дотор”, “цагийн+орчим, турш” гэх хэлбэрээр тохиолдоно.
- Өсвөр насны эхэн үе буюу 11-13 насны хооронд тархины хоёр дах эрчимтэй хөгжил явагддаг (eagle.mn) гэсэн өгүүлбэрийг “Өсвөр насны эхэн үе буюу 11-13 насанд тархины хоёр дах эрчимтэй хөгжил явагддаг” эсвэл “Өсвөр насны эхэн үе буюу 11-ээс 13 нас хүртэл тархины хоёр дахь эрчимтэй хөгжил явагддаг” гэх зэргээр найруулан бичиж болно.
 - хоёр үйл явдлын хооронд
 - Өөрөөр хэлбэл, өдөрт үндсэн 3 хоол, *завсар хооронд нь* 2-3 удаа жижиг зууш хэлбэрээр хооллох нь хоногийн зохистой хооллолтын үндэс юм. (ikon.mn)
 - хоёр ба хэд хэдэн үйл явдлын хоорондын хамаарал
 - ... үдийн болон оройн хоолны хоорондох зууш... (ikon.mn)
 - тодорхой хязгаартай үргэлжлэх хугацаа
 - Гучин цагийн хооронд ажиллах ажээ (www.dailynews.mn) гэж ярианы хэлний өгүүлбэр дэх “хооронд”-ийг “дотор” гэх үгээр солин найруулж “гучин цагийн дотор” гэж яриа ба бичгийн хэлэнд ашигладаг.
3. Хоёр ба түүнээс дээш зүйлийн хязгаарт тоо, хэмжээний утга
- хоёр тооны хооронд. Жишээ нь: Хувьцааны үнэ тайлант хугацаанд 1,200-1,750 *төгрөгийн хооронд* хэлбэлзэж... (www.arddaatal.mn)
 - бүлэг тооны хязгаар, хэмжээ. Жишээ нь: Үнэндээ иррационал тоо нь үргэлж хоёр рационал *тооны хооронд* оршино. (mn.khanacademy.org); 1/5 ба 1/4-ийн *хооронд* орших рационал тоо аль вэ? (www.integral.mn)
4. Хоёр ба түүнээс дээш хүмүүс мөн бүлэг хүмүүсийн хооронд
- Монголын жүдо бөхийн холбооноос *хоёр тамирчны хооронд* “Токио 2020” зуны олимпын наадамд эрэгтэйчүүдийн 60 кг жинд эх орноо төлөөлөн оролцох эрхийн төлөө сорилго барилдаан хийхээр шийджээ; Зуны Олимпын XX наадмын сагсан бөмбөгийн эрэгтэйчүүдийн тэмцээний алтан медалийн төлөө тоглолт тэр үдэш АНУ-ЗХУ-ын *шигшээ багуудын хооронд* болсон юм (<https://news.zindaa.mn>). Дээрх жишээнүүдэд *qoyirundu* гэх үг нь уралдаан тэмцээн, маргаан, уулзалт хэлэлцүүлгийн үед хоёр ба түүнээс дээш хүмүүс мөн бүлэг хүмүүсийн хооронд эсрэгцсэн утгыг илтгэнэ.
5. Хоёр ба түүнээс олон зүйлийн юмс үзэгдлийг ялган салгах, харьцуулж жиших аргаар тодруулах
- а) насны үечлэлийн ялгаа
 - Gen Z, Millennials, Boomers: үе хоорондын ялгааг ойлгох нь (www.unread.today) гэх нийтлэлийн гарчиг нь “нурууны нугалам хооронд, үе хоорондын зааг” гэх ойлголтоор бичсэн байна. Гэвч энэ тохиолдолд “... үеийнхний ялгаа” гэж найруулж бичих нь зохимжтой юм.
 - б) хоёр юмын ялгаа
 - Масс ба жин хоорондын ялгааг харьцуулах хүснэгтийг энд үзүүлэв (<https://mn.eferrit.com>) хэмээн энгийн ярианд солин нэрлэж болох ойлголт мэт боловч мөн чанарыг нь харьцуулан жишиж үзвэл ялгааг нь салгаж ухаараад ижил биш зүйлийг ялгааг нь тодруулан найруулж бичих боломжтой юм.

- 6) Хэлц утга: “*qoyurundu*” гэх орон цагийн нэр нь хэл зүйн үүргээ утга шилждэг. Жишээлбэл, алга урвуулахын хооронд, нүд анихын хооронд, зуур хооронд, хүүе хаая гэхийн хооронд гэх мэтээр хурдан, түргэн, хоромхон хугацаанд болж өнгөрөх агшин буюу цагийн утгаар тохиолдох бол хоёрын хооронд, хоёрын хооронд гурвын дунд, эр эмийн хооронд илжиг бүү жороол гэх мэтээр тухайн нөхцөлд үүсэх завсрын байдал, алинд нь ч үгүй, дэмий гэсэн утгаар хам сэдвээс үүдэн утга нь тодорхой болно. Мөн “*унтах сэрэх хоёрын хооронд байтал...*” (www.dailynews.mn) гэхийг “*унтах сэрэхийн завсар*”, “*үхсэн амьдын хооронд*” гэх мэтээр “завсрын, аль нь ч биш” гэх утгаар найруулгын төрлөөс шалтгаалан солин найруулж болно. “*qoyurundu*” гэх үг нь хэл зүйд чухал үүрэгтэй нь найруулга зүйн алдааны анализ (error analysis) хийхэд утгын ялгааг нь нарийн ухаараагүйгээс найруулгын алдаа үүсдэг байна.

Үүнээс дүгнэвэл, монгол хэлний *dumda*, *qoyurundu*, *jayūr-a*, *jabsar* зэрэг үгс нь ерөнхийдөө орон цагийн холбоо хамаарлыг илэрхийлэхдээ юмс үзэгдлийг хоёр ба түүнээс дээш юмсын дунд эсвэл орон зай, цаг хугацааны дотор, тодорхой хүрээ хязгаарт зогсонги, хөдлөнгө утгыг илэрхийлж байгаа ч хязгааргүй орон цагийн утгыг заадаггүй бөгөөд энгийн өгүүлбэрт орон цагийн байц гишүүний үүргээр орно.

Монгол хэлний төгс бус өгүүлэхүүний хэл зүйн хэлбэр болох задлаг бүтцийг бий болгоход *dumda*, *qoyurundu*, *jabsar*, *jayūr-a* гэх орон цагийн нэр тодорхой үүрэгтэй. Үүнийг Е.К.Скрибник судлаад, өгүүлэхүүний гол бүрэлдэхүүн болох цагт нэр нь тэг үндэс буюу ерөнхийлсөн хэлбэр (обобщенная формула) мөн гарах болон харьяалахын тийн ялгалаар хэлбэржин “дээрхээ, хойно, хойшо, тээшэ, *зabhapma*, зуура” зэрэг үгийг ардаа авч “цаг, үе, хир, зорилгоор, зэргээр, талаар, биеэр, зангаар, хэвээр, горимаар, чигт, самбаанд, хажуугаар, оронд, зайгаар, сүүлээр, ёсоор” (1988) зэрэг орон цагийн утгатай жинхэнэ нэрийг дагуулдгийг буриад хэлний жишээгээр тайлбарласан бол Б.Пүрэв-Очир төгс бус өгүүлэхүүний бүтэц дэх орон цагийн нэрийг академич Ш.Лувсанвандангийн адилаар энэ нь дагуул биш, гол бүрэлдэхүүн болж орсон “... *хэлэхийн завсар бодох*, үүр цайхын үес одох” гэх мэт холбоо үгийн жишээ татахын хамт “өнчин цагаан ботго нь ногоо *гандаад ирэхийн цагт* өөрийн хайрт ээжээ санаад ... түүнээс өмнөхөн аавыг *түр зуур гарах хооронд* хоёр лам бие биеэ харалцан ... Бурхны өмнө бадарч байсан зул бөхсөнөөс хойш нэлээд цаг удаж, *шөнө дунд* өнгөрөхийн орчимд гавж лам нэгэн зүүд зүүдлэв.” (Ц.Дамдинсүрэн) гэх жишээ татжээ. Энэ мэт баримт сэлтийг үзэхэд, орчин цагийн монгол хэлэнд нэг үгийг нөгөө үгтэй найруулан холбож харьцааны утга илрүүлэх “*өмнө, дунд, гадна, өөд, уруу, дараа, доогуур, үес, талаар, хойно, дээрээ, турш, хойш, хажууд, дотор, зуур, дэргэд, цаана, завсар, (дагуу), даруй, тушаа, хооронд, орчимд, дараа*” гэх зэрэг харьцааны нэр хэрэглэж байна (Пүрэв-Очир, 1988) гэжээ. Иймд төгс бус өгүүлэхүүний бүтэц дэх дагуул биш, гол бүрэлдэхүүн болж орсон *dumda*, *qoyurundu*, *jabsar*, *jayūr-a* гэх орон цагийн нэрийг жишээгээр авч үзье.

- - х хооронд, -х+ын хооронд, -х-ын хооронд+гүй
 - За, найз чинь *ирэхийн хооронд* яасан их утсаар ярьдаг юм бэ?
 - Мөдхөн *хүрээд ирэхийн хооронд* битгий санаа зов доо.
 - Сайхан зүүднээсээ *сэрэхийн хоорондгүй* л алга болчихлоо.
 - Би аргалаа хучихын хоорондгүй бороо асгарчихлаа.
- -х зуур, -х+ын зуур
 - Биднийг *ярилцах зуур* гэрийн эзэгтэй бага хүүгээ хөтлөн ажил, сургуульдаа яаран гарч одов.
 - Нүд ирмэхийн зуур л болоод өнгөрсөн дөө хөөрхий.
 - Тухайлбал, анчныг бүргэдээ дуудахад өндөрт нисэж буй бүргэд нүд ирмэхийн зуур ирж эзнийхээ гарын шуун дээр суух ёстой (www.dailynews.mn).

- -х завсар, -х-ын завсарт

- Чилсэн биеийг тайвшруулан түр зуур *хэвтэхийн завсар* энэ өдрийн ЭЛДЭВ хэргийг бодох бөгөөд өдрийн тэмдэглэлийн дэвтрээ дэрэн дороосоо авч үзвэл, химик харандаагаар бичсэн хэдэн үсэг бүдэг бадаг үзэгдэхэд түүнийг шүлсээрээ норгон, улмаар ажиглавал... (Д.Н. “Харанхуй хад”); - “Цай авчирья” хэмээн *гарч одохын завсар* ламыг ажиглавал... (Д.Н. “Ламбугайн нулимс”); - Хүүхдүүд ээ, бороо зогсохын завсарт бүгдээрээ аргалаа оруулья.

Үүнээс үзвэл, -х/ын зуур, -х-ын хооронд, -х-ын завсарт гэх хэлбэр нь зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрт давхцан зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн үүргээр орно.

Харин *ene/tere+qoyurundu, jayür-a, jabsar* гэх хэлбэр нь нийлмэл өгүүлбэр болон цогцолборт зэрэгцсэн цаг заасан өгүүлбэрийн эхэнд гадаад холбоосны үүргээр тохиолдож байна. Тухайлбал,

- *ene/tere + qoyurundu*
 - Энэ хооронд нэлээн хэдэн дүр дээр ажиллаж, түүнийг маань ард түмэн төр засаг тодорхой хэмжээнд үнэлсэн л дээ (www.dailynews.mn).
 - Морь маань үе үе авч шуугиад л. Тэр хооронд хаячихгүй юу (www.dailynews.mn).
- *ene/tere + jayür-a*
 - Энэ зуур ээж Ж.Мягмарсүрэн гуайтай ярилаа (www.dailynews.mn).
 - Энэ зуур төмөр замын бодлогын баримт бичгүүд Таван толгойн ордыг ашиглах гэрээ батлагдаж дууслаа (www.dailynews.mn).
 - Энэ зуур бидний сэтгэлд хорвоог орхин одсон сайн сайхан хүмүүс минь санаанд бууж байлаа (www.dailynews.mn).
- *ene/tere + jabsar*
 - Энэ завсар миний сэтгэлд баяр төрж авай (Д.Н. “Харанхуй хад”).
 - Энэ завсар айраг идээгээ барьцгааж тоглоом наадлаа (Д.Нацагдорж).
 - Энэ завсар Дагдангийн эхнэрийн таргалсан, Цэрмаагийн турсан хоёр яг тэнцэнэ. (Д.Н. “Цагаан сар ба хар нулимс”)
 - Энэ завсар Одбаяр утсаар ярьж удалгүй “Эзэгтэй” үйлдвэрээс таван боодол гоймон авч ирэв (www.dailynews.mn).
 - ... тэр завсар жаахан алгуурлаж байтал... (www.dailynews.mn)

Үүнээс үзвэл, “*ene/tere+dumda*” гэх хэлбэр холбох үгийн үүргээр тохиолдохгүй байна. Монгол хэлний *ene/tere* гэх заах төлөөний үг нь “тэр айлын зүг, тэр танхимд”, “тэр үед, тэр өдөр”, “энэ хооронд, тэр завсар” гэхэд орны цагийн утгатай нэр үг болон орон цагийн нэрийн өмнө хамжсан тодотголын үүргээр тохиолдоно. “*ene/tere+jil, sar-a, edür, uday-a, iй-e*”, *ene/tere+qoyurundu, jayür-a, jabsar* гэх хэлбэр нь өгүүлбэрийн эхэнд ихэвчлэн тохиолдож байгаа ч өмнөх өгүүлбэртэйгээ зэрэгцсэн цагийн утгатай холбох үгийн үүргээр орж өгүүлбэрийн гадаад холбоосоор тохиолдож буй нь сонирхолтой юм.

Монгол хэлэнд “*qoyurundu*” гэх үгсийн үүрэг-утга зүйн онцлог нь төдий л нарийн анзаарагдахгүй боловч хэлний хэрэглээнд утгын ялгаа нь тодорхой болдог. Өөрөөр хэлбэл, орон зай, цаг хугацааны хэмжүүр нь энгийн ойлголт мэт боловч, тухайн үг, холбоо үг, өгүүлбэр, хам сэдвээс ангид ухаарах боломжгүй хийгээд хэл зүй, утгын хувьд нягт холбогдсон байхын сацуу найруулгын өнгө аясад ч чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол хэлэнд “*qoyurundu*” гэх үг нь хоёр ба түүнээс олон юм үзэгдлийн хоорондох орон цагийн харьцааг илэрхийлэхийн зэрэгцээ утга шилжин хийсвэржиж хэрэглэгдэх болсон тул цаашид хэлэхүйн үйлдэл болон учир зүй нарийн эрэмбэ дараатай хэлц, хэллэг болон хам сэдвийн хүрээнд *dumda, jayür-a (jabsar)* зэрэг ойролцоо утгат орон цагийн нэртэй солин найруулж, үүрэг-утга зүйн онцлогоор нь хэрэглээний хүрээг танин мэдэж болно.

Resume

This article has described the structural and functional characteristic of the structures with the place-time relative noun “qoyurundu” in modern Mongolian. However, to the synonymy of lexical words with their lexical stem, however, we can ignore these complications in the following and concentrate on the corresponding lexical word as far as semantics is concerned. In particular, we have shown on the example of “qoyurundu” that the intension of grammatical function, lexical meaning and usage of adverb.

Номзүй

Ramstedt G.J. 1935. *Kalmückisches Wörterbuch*. Helsinki: Der Finnischen Literatur Gesellschaft.

Schmidt I.J. 1831. *Grammatik der Mongolischen Sprache*. St. Petersburg.

Алексеев Д.А. 1962. *Грамматика бурятского языка. Фонетика и морфология. Послелог*. Москва.

Базаррагчаа М. 2005. *Монгол хэлний өгүүлбэр судлал*. Улаанбаатар.

Барайшир Ш. 1974. *Орчин цагийн монгол хэлний дайвар үг*. Улаанбаатар.

Бямбасан П. 1968. *Зарим дайвар үгийн тухай*. Хэл зохиол судлал. Т-V, fasc. 3. Улаанбаатар.

Дарбаева А.А. 1962. *Грамматика бурятского языка, (Фонетика и морфология)*. Москва.

Жанчивдорж Ц. 1970. *Монгол хэлний үг зүй*. (Сурах бичиг). Улаанбаатар.

Лувсанвандан Ш. 1939. *Монгол хэлний зүй*. (Сурах бичиг). Улаанбаатар.

Лувсанвандан Ш. 1951. *Монгол хэлний зүй*. Улаанбаатар.

Лувсанвандан Ш. 1968. *Орчин цагийн монгол хэлний бүтэц*. Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь. Улаанбаатар.

Лувсандэндэв А. 1956. *Монгол хэлний үгсийг аймаглах тухай асуудалд*. Монгол үндэсний хэл бүрэлдэн тогтсон нь. Улаанбаатар.

Монгол утгын зүйл хуваасан толь бичиг. 1956. Бээжин.

Өнөрбаян Ц. 2004. *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар.

Пүрэв-Очир Б. 1988. *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүйн холбох тогтолцоо*. Улаанбаатар.

Санжеев Г.Д., & 1962. *Грамматика бурятского языка. Фонетика и морфология*. Москва.

Скрибник Е.К. 1988. *Полипредикативные синтетические предложения в бурятском языке*. Новосибирск.

Сүхбаатар Ц. 2012. *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар.

Тодаева Б.Х. 1951. *Грамматика современного монгольского языка*. Москва. стр.

Цыдыпов Ц.Ж. 1972. *Аналитические конструкции в бурятском языке*. Улан-Удэ. стр.